



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУЛГАН СУМЫН ЗУРГААДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БУА-2021/20/СТА-ТШЗ

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АО	Ажил олгогч
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН СУМЫН ЗУРГААДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.БАЯРМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн, үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагаа зогсоосон байхад хоолны мөнгө олгосон, зардлыг батлагдсан төсөв, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчлүүд нь УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2014 оны 55, 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,803,455.26</u>	<u>44,409,111.26</u>
33	АВЛАГА	-	7,500,000.00
335	Бусад авлага	-	7,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	7,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,803,455.26	36,909,111.26
351	Түүхий эд материал	37,955,175.26	124,100.00
35130	Эм боох материал	112,100.00	124,100.00
354	Хангамжийн материал	6,848,280.00	36,785,011.26
35410	Бичиг хэргийн материал	1,519,700.00	571,800.00
35420	Аж ахуйн материал	400,500.00	22,463,104.40
35440	Түлш, шатах тослох материал	230,000.00	230,000.00
35460	Хүнсний материал	4,698,080.00	2,327,790.00
35470	Бусад хангамжийн материал	-	11,192,316.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>443,814,816.28</u>	<u>444,702,715.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	443,814,816.28	444,702,715.28
392	Биет хөрөнгө	402,104,399.55	401,532,298.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	387,901,207.26	387,901,207.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,583,624.56)	(24,682,140.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,324,135.91	27,574,888.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,383,323.69)	(5,896,113.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,641,845.66	22,353,053.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,529,576.25)	(11,006,731.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,098,514.40	7,098,514.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,364,779.18)	(4,611,801.24)
39217	Ном	-	2,936,422.00
393	Биет бус хөрөнгө	41,710,416.73	43,035,416.77
39301	Програм хангамж	250,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(39,583.27)	(64,583.23)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,500,000.00	41,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>488,618,271.54</u>	<u>489,111,826.54</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>488,618,271.54</u>	<u>489,111,826.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	488,618,271.54	489,111,826.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	151,245,003.07	151,245,003.07
51101	Өмч: - төрийн	151,245,003.07	151,245,003.07
512	Хуримтлагдсан үр дүн	(44,271,090.87)	(43,777,535.87)
51210	Өмнөх үеийн үр дүн	(44,271,090.87)	(44,271,090.87)
51220	Тайлант үеийн үр дүн	-	493,555.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,644,359.34	381,644,359.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>488,618,271.54</u>	<u>489,111,826.54</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	373,999,885.00	476,603,213.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,796,585.00	423,012,313.76
120	Нийтлэг татварын бус орлого	5,796,585.00	46,985,713.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,796,585.00	5,905,018.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,796,585.00	5,905,018.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		29,275,899.26
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		11,804,796.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	376,026,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	376,026,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,203,300.00	53,590,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,897,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,897,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,305,500.00	53,590,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,305,500.00	53,590,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	377,345,599.63	436,913,463.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,345,599.63	436,913,463.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,496,462.14	387,241,110.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,035,734.00	259,461,267.00
210101	Үндсэн цалин	163,323,000.00	162,012,826.00
210102	Нэмэгдэл	27,119,587.00	63,421,138.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,467,500.00
210104	Урамшуулал	30,593,147.00	24,559,803.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,339,384.51	33,082,880.00
210201	Тэтгэврийн даатгал	18,860,291.00	22,513,159.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,154,601.51	2,642,430.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,732,144.00	2,113,944.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,485.00	528,486.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,174,863.00	5,284,861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,136,551.00	53,096,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,981,511.00	3,201,610.00
210302	Түлш, халаалт	51,296,900.00	47,432,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,858,140.00	2,462,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,532,440.90	3,725,990.00
210401	Бичиг хэрэг	787,700.00	546,700.00
210402	Тээвэр, шатахуун	209,400.00	269,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,449.00	463,700.00
210404	Ном, хэвлэл	-	7,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	720,450.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,497,229.20	1,717,740.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	429,600.00	-
210408	Бараа материал акталсны зардал	2,308,062.70	-
2105	Нормативт зардал	38,848,176.00	16,775,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	26,350.00
210502	Хоол, хүнс	37,970,476.00	16,387,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	877,700.00	362,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,390,855.00	743,850.00
210604	Урсгал засвар	1,390,855.00	743,850.00
2107	Томилолт, зочны зардал	90,400.00	-
210702	Дотоод албан томилолт	90,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	402,400.00	539,080.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,400.00	323,080.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,720,520.73	19,815,303.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,625,168.00	222,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	671,900.00	357,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,423,452.73	19,235,003.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,849,137.49	49,672,353.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,000.00	750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,137.49	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,137.49	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	48,922,353.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	48,922,353.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,345,714.63)	39,689,750.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,696,585.00	39,196,195.26
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,696,585.00	39,196,195.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,696,585.00)	(39,196,195.26)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,042,299.63)	493,555.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	368,203,300.00	433,282,825.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	379,691,925.00	
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,665,325.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,665,325.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,665,325.00	

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	376,026,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	376,026,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	368,203,300.00	53,590,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	307,897,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,897,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,305,500.00	53,590,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,305,500.00	53,590,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	358,720,300.00	428,351,515.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,720,300.00	428,351,515.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,871,162.51	378,679,162.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,035,734.00	259,461,267.00
210101	Үндсэн цалин	163,323,000.00	162,012,826.00
210102	Нэмэгдэл	27,119,587.00	63,421,138.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,467,500.00
210104	Урамшуулал	30,593,147.00	24,559,803.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,339,384.51	33,082,880.00
210201	Тэтгэврийн даатгал	18,860,291.00	22,513,159.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,154,601.51	2,642,430.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,732,144.00	2,113,944.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,485.00	528,486.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,174,863.00	5,284,861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,305,500.00	53,096,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,981,511.00	3,201,610.00
210302	Түлш, халаалт	51,465,849.00	47,432,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,858,140.00	2,462,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,775,979.00	4,501,890.00
210401	Бичиг хэрэг	108,400.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	209,400.00	269,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,449.00	463,700.00
210404	Ном, хэвлэл	28,950.00	68,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,235,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,128,780.00	1,964,740.00
2105	Нормативт зардал	40,668,275.00	18,303,975.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,100.00	38,350.00
210502	Хоол, хүнс	40,002,475.00	17,682,325.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623,700.00	583,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,010,000.00	494,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	494,100.00
2107	Томилолт, зочны зардал	90,400.00	-
210702	Дотоод албан томилолт	90,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,400.00	501,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	207,400.00	285,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,438,490.00	9,237,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,700,390.00	881,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,738,100.00	8,355,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,849,137.49	49,672,353.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,000.00	750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,137.49	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,137.49	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	48,922,353.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	48,922,353.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,483,000.00	4,931,310.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,483,000.00	4,931,310.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,483,000.00	4,931,310.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,483,000.00	4,931,310.00
222001	Тоног төхөөрөмж	7,979,000.00	2,915,900.00
223001	Бусад хөрөнгө	1,504,000.00	2,015,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,483,000.00)	(4,931,310.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(44,271,090.87)	488,618,271.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(44,271,090.87)	488,618,271.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(44,271,090.87)	488,618,271.54
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(44,271,090.87)	488,618,271.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(44,271,090.87)	488,618,271.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	493,555.00	493,555.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,777,535.87)	489,111,826.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны	
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	367,104,162.51	434,332,100.00	384,360,472.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,104,162.51	434,332,100.00	384,360,472.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	366,354,162.51	433,582,100.00	383,610,472.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,035,734.00	276,514,400.00	259,461,267.00
210101	Үндсэн цалин	163,323,000.00	168,654,200.00	162,012,826.00
210102	Нэмэгдэл	27,119,587.00	66,409,700.00	63,421,138.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,405,000.00	9,467,500.00
210104	Урамшуулал	30,593,147.00	31,045,500.00	24,559,803.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,339,384.51	36,046,900.00	33,082,880.00
210201	Тэтгэврийн даатгал	18,860,291.00	24,966,400.00	22,513,159.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,154,601.51	2,770,100.00	2,642,430.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,732,144.00	2,216,100.00	2,113,944.00
210204	Ажилгүйдлийн даатгал	417,485.00	554,000.00	528,486.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,174,863.00	5,540,300.00	5,284,861.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,305,500.00	57,305,500.00	53,096,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,981,511.00	3,400,000.00	3,201,610.00
210302	Түлш, халаалт	51,465,849.00	50,455,500.00	47,432,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,858,140.00	3,450,000.00	2,462,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,422,379.00	5,145,600.00	4,501,890.00
210401	Бичиг хэрэг	108,400.00	500,000.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	209,400.00	270,000.00	269,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,449.00	508,600.00	463,700.00
210404	Ном, хэвлэл	28,950.00	68,500.00	68,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,700,000.00	1,235,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,180.00	2,098,500.00	1,964,740.00
2105	Нормативт зардал	40,668,275.00	41,741,100.00	18,303,975.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,100.00	58,000.00	38,350.00
210502	Хоол, хүнс	40,002,475.00	41,099,800.00	17,682,325.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623,700.00	583,300.00	583,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	1,000,000.00	494,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00	-	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	494,100.00
2107	Томилолт, зочны зардал	90,400.00	384,300.00	-
210702	Дотоод албан томилолт	90,400.00	384,300.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,400.00	2,214,200.00	1,851,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	207,400.00	648,200.00	285,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	216,000.00	216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,350,000.00	1,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,785,090.00	13,230,100.00	12,818,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,046,990.00	2,698,000.00	2,286,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,738,100.00	10,532,100.00	10,532,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750,000.00	750,000.00	750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	750,000.00	750,000.00	750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	750,000.00	750,000.00	750,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	367,104,162.51	434,332,100.00	384,360,472.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	306,798,662.51	376,026,600.00	327,104,247.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	306,798,662.51	376,026,600.00	327,104,247.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,305,500.00	58,305,500.00	53,590,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	60,305,500.00	58,305,500.00	53,590,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	3,665,325.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			3,665,325.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	8.00	8.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	164.00	140.00	140.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	164.00	140.00	140.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	164.00	140.00	140.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	22.00	22.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00	13.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Ц.Баярмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, УСНББОУС-ын дагуу бараа материалын тайлангийн дансны ангиллыг үнэн зөв бүртгээгүй, анхан шатны баримт нь И баримтаар нотлогдохгүй байгаа талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор Г.Цэрэнлхам хариуцаж гүйцэтгэв.

Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Тус цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхийг зорин ажиллажээ. Мөн хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь заалт,
- Засгийн газрын “Хоолны зардлын дундаж норматив батлах” тухай 2019 оны 450 дугаар тогтоол,
- Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах” тухай 2020 оны 181 дүгээр тогтоол,
- Засгийн газрын “Цэцэрлэг сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд түр зогсоох хугацаанд үдийн хоол, үдийн цайн зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг Бямба гаригт ажиллах багш ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагын ариутгал халдваргүйжүүлэлтэд зарцуулах” тухай 2020 оны 64 дүгээр тогтоол,
- Засгийн газрын “Хүнсний дэмжлэг үзүүлэх” тухай 2020 оны 188 дугаар тогтоол,
- Засгийн газрын “Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 139 дүгээр тогтоол,
- БСШУС-ын “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах” тухай 2020 оны А/224 дүгээр тушаал,
- БСШУС-ын “Заавар батлах тухай” 2020 оны 4/296 дугаар тушаал,
- БСШУС-ын “Төсөвт зохицуулалт хийх тухай” 2020 оны а/2788 тоот албан тоот

- БСШУС-ын “Зөвлөмж хүргүүлэх тухай хичээлийн сургалт түр хугацаагаар зогсоохтой холбоотой төсөв санхүүгийн харилцааг зохицуулах” тухай 2020 оны а/522 тоот албан тоот,
- БСШУС-ын “Зөвлөмж хүргүүлэх” тухай 2020 оны а/2018 тоот албан тоот,
- БСШУС-ын “Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах” тухай 2020 оны а/281 тоот албан тоот,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын 6-р цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган сумын 6-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 381,612.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,632.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өмнөх онд хязгаарлалттай санал дүгнэлт авсан учир материаллаг байдлын түвшинг бууруулан 1 хувиар тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 493.5 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		7,500.0	7,500.0
Бараа материал	44,803.5	36,909.1	(7,894.4)
Үндсэн хөрөнгө	443,814.8	444,702.7	887.9
Нийт хөрөнгө	488,618.3	489,111.8	493.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	488,618.3	489,111.8	493.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	488,618.3	489,111.8	493.5

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Оны эцэст цалингийн урьдчилгааны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 7,500.0 мянган төгрөг болж өссөн нь Номин ногоон тал ХХК, Битачи ХХК хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,909.1 мянган төгрөг болж 7,894.4 мянган төгрөгөөр буурсан нь дансны ангилал буруу бүртгэсэн тусгай зориулалтын материалын данснаас үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэсэн, өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас тус тус шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 489,111.8 мянган төгрөг болж 493.5 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө, БСШУЯ-аас хандиваар ирсэн суурин компьютер, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн дансны үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор үүссэн үнэ төлбөргүй орлогоор нэмэгдэж, байгууллагын өмч хамгаалах комиссын шийдвэрээр машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийг акталж данснаас хассанаас тус тус шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 488,111.8 мянган төгрөг болж 493.5 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ өртгөө нөхөж дуусаагүй, үлдэх өртөгтэй хөрөнгийг данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 360,210.4 мянга, орон нутгийн төсвөөс 70,209.8 мянга, нийт зарлагыг 430,420.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 3,911.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 434,332.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг санхүүжүүлэх 376,026.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 58,305.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 589,337.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 502,082.1 мянган төгрөгийг зарцуулан, 48,922.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 644.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт

		/мянган төгрөг/		
Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	(3,665.33)	3,665.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	276,514.40	259,461.27	17,053.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	36,046.90	33,082.88	2,964.02
2104	Хангамж, бараа материалын зардал	5,145.60	4,501.89	643.71
2103	Байр ашиглалттай хол тогтмол зардал	57,305.50	53,096.80	4,208.70
2105	Нормативт зардал	41,741.10	18,303.98	23,437.13
2107	Томилолт, зочны зардал	384.30	-	384.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үй	2,214.20	1,851.00	363.20

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,230.10	12,818.51	411.59
213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал	750.00	750.00	-

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, АО-ийн нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн нь дэлхий нийтээр тархаад байгаа Ковид-19 цар тахал гарч хол хорио тогтоосноор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа зогссон, багш нарын илүү цаг, ур чадвар, хоолны мөнгийг олгоогүй зэргээс нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй болно.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 1 мэдээлэл хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 33.6 сая төгрөгийн 7 зөрчилд, 0.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 33.1 сая төгрөгийн 3 албан шаардлага, 0.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн
Төлбөрийн акт	2	0.9	2	0.9	100.0	-	-
Албан шаардлага	3	31.1	3	31.1	100.0	-	-
Зөвлөмж	2	1.6	2	1.6	100.0	-	-
Нийт дүн	7	33.6	7	33.6	100.0	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 509,777.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 3,380.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоож, 3,178.0 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 1 төлбөрийн албан шаардлага өгч, 503,219.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг алдаа илрээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар аудитаар 6,558.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснийг төлбөрийн акт тогтоохоор хүргүүлэв. Үүнд:

1. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Улсын онцгой комиссын шийдвэрээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг зогсоож танхимаар хичээллээгүй байхад хоолны мөнгө ажилчдад цалингийн зардлаас 3,380.0 мянган төгрөг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

2. УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй тооцоолсон 3,178.0 мянган төгрөгийн нийт цалинг зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилт хийхгүйгээр шууд цалингийн зардалд бичсэн байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилаагүй тул зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

- 3.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 503,219.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд УСНББОУС-ын дагуу бараа материалын тайлангийн дансны ангиллыг үнэн зөв бүртгэж байгаа эсэх, Мөн цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагад очиж хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийгээгүй тул цаашид хөрөнгийн ашиглалтын хугацаа, хадгалалт, хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Бараа материалын ангиллыг буруу үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна. /Бичиг хэргийн материалын дансанд 240 нэр төрлийн ном, Тусгай зориулалтын материал дансанд 334 нэр төрлийн засварын материал, тоног төхөөрөмж, номыг бүртгэсэн/. Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

1.2 Эрсдэл: Үндсэн хөрөнгийг холбогдох шийдвэргүйгээр шаардахаар зарлагдах.

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж дансны ангиллыг зөв бүртгэх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах” заалтыг иөрдөж өр авлага үүсгэхгүй ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, Бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл: Хөрөнгийн тооллого дутуу хийгдэж, тухайн байгууллагад хөрөнгө бодитоор оршин байхгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлэн, анхан шатны баримтыг бүрэн хөтөлж, хөрөнгийн тооллогыг бүрэн хийж, үлдэгдлийг баталгаажуулж хэвших.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлийг баталгаажуулж ирүүлсэн.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Булган сумын 6-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БУА-2021/20/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Булган сумын 6-р цэцэрлэг	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ковид-19 халдварт өвчин гарч Улсын онцгой комиссын шийдвэрээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг тахимаар хичээлээгүй байхад хөдөлмөрийн дотоод журамд тусгагдаагүй хоолны мөнгө ажилчдад цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	3,380.0	Холбогдох захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоох	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Баярмаа, П.Мөнхзаяа
2	Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн.	3,178.0	Тооцооны дансаар дамжуулж, стандартын дагуу НББ хөтөлж байх албан шаардлага хүргүүлээ.	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Баярмаа, П.Мөнхзаяа
3	Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэсэн байна	7,500.0	УСНББОУС-12 Бараа материалын стандартын дагуу зөв ангилж бүртгэх зөвлөмж хүргүүлээ.	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Баярмаа, П.Мөнхзаяа
4	Бараа материалын ангиллыг буруу үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна. /Бичиг хэргийн материалын дансанд 240 нэр төрлийн ном, Тусгай зориулалтын материал дансанд 334 нэр төрлийн засварын материал, тоног төхөөрөмж, номыг бүртгэсэн/. Энэ нь оршин байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.	14,107.9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж дансны ангиллыг зөв бүртгэх зөвлөмж хүргүүлээ.	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Баярмаа, П.Мөнхзаяа



5	Үндсэн хөрөнгө, Бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон бодсон баталгаажуулаагүй байна. актаар	481,611.8	Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар бараа материал, үндсэн хөрөнгийн данс тус бүрээр тооцоо бодсон актаар үлдэгдлийг баталгаажуулах зөвлөмж хүргүүлээ.	Эрхлэгч Нягтлан бодогч	Ц.Баярмаа, П.Мөнхзаяа
ДҮН		509,777.7			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ

Огноо: 2021/02/28

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

Огноо: 2021/02/28

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

Огноо: 2021/02/28